

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР-ДИЛЕРИЙН КОМПАНИД  
ЗАХИАЛГЫН ГЭРЭЭ, ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ,  
ДИЛЕРИЙН ДААЛГАВРЫН МАЯГТЫГ  
ХӨТЛӨХ ЗААВАР

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.Үнэт цаасны брокер, дилерийн компанид үнэт цаасны захиалгын гэрээ, захиалгын бүртгэл, дилерийн даалгаврыг дараахь маягтаар хөтөлнө:

- 1.Үнэт цаасны захиалгын гэрээ Маягт №А2-1
- 2.Үнэт цаасны захиалгын бүртгэл Маягт №А2-2
- 3.Үнэт цаасны дилерийн даалгавар/худалдах захиалгын/ Маягт №А2-3А
- 4.Үнэт цаасны дилерийн даалгавар/худалдан авах захиалгын/ Маягт №А2-3Б
- 5.Үнэт цаасны дилерийн даалгавар/компанийн өөрийн захиалгын/ маягт №А2-3В

2.Маягтын үзүүлэлтийг дараахь байдлаар үйлдэнэ:

- 1/"Захиалгын гэрээний дугаар" гэсэн хэсэгт харилцагчтай байгуулсан гэрээний дугаарыг,
- 2/"Захиалагчийн овог, нэр" гэсэн хэсэгт хувь хүн бол харилцагчийн овог, нэр, аж ахуйн нэгж бол оноосон нэрийг,
- 3/"Дансны дугаар" гэсэн хэсэгт харилцагчийн дансны дугаарыг,
- 4/"Үнэт цаасны нэр, төрөл" гэсэн хэсэгт: худалдах эсхүл худалдан авах үнэт цаасны нэр, төрлийг,
- 5/"Захиалга өгсөн он, сар, өдөр, цаг, минут" гэсэн хэсэгт захиалга хийсэн хугацааг,
- 6/"худалдах, эсхүл худалдан авах" гэсэн хэсэгт худалдах буюу худалдан авахын аль нь болохыг,
- 7/"Захиалгын төрөл, нөхцөл" гэсэн хэсэгт захиалгын төрөлд: тендерийн эсхүл энгийн захиалга, зах зээлийн, хязгаарлагдмал, захиалга зогсоох нөхцөлд: нэг өдрийн эсхүл үргэлжлэх, багцалж худалдах, мөн ширхгээр худалдах зэрэг үнийн, цаг хугацааны, тоо хэмжээний болон бусад нөхцөлүүдийг,
- 8/"Захиалгын тоо ширхэг" гэсэн хэсэгт үнэт цаасны худалдах, худалдан авах тоо, ширхгийг,
- 9/"Захиалгын нэгжийн үнэ" гэсэн хэсэгт үнэт цаасны үнийг,
- 10/"Захиалгын биелэлт" гэсэн хэсэгт биелсэн захиалгын цаг хугацаа, тоо, ширхэг, нэгжийн болон нийт үнийг,
- 11/"Шимтгэлийн хувь, дүн" гэсэн хэсэгт шимтгэл авахаар тохиролцсон хэмжээ, үнийн дүнг,
- 12/"Хэлцлийн дугаар, хэлцэл хийсэн он, сар, өдөр, цаг, минут" гэсэн хэсэгт хэлцлийн дугаар, хэлцлийн огноог тус тус бичнэ.

ХОЁР. Үнэт цаасны захиалгын гэрээ/маягт А2-1/

3.Харилцагчид брокер-дилерийн компанитай үнэт цаас худалдан авах, худалдах үнэт цаасны захиалгын гэрээг маягт №А2-1-ийн дагуу 2 хувь үйлдэнэ. Нэгдүгээр хувь нь харилцагчид, хоёрдугаар хувь нь брокер-дилерийн компанид үлдэнэ.

4. Үнэт цаасны захиалгын гэрээний дугаарыг зөвхөн захиалгын бүртгэл хөтлөгч үйлдэнэ. Захиалгын бүртгэл хөтлөгч олгосон дугаараа баталгаажуулсан тэмдэг дарж, үнэт цаасны захиалгын бүртгэлд /маягт №А2-2/ дугаарыг тэмдэглэнэ. Үнэт цаасны захиалгын гэрээний дугаарыг давхардуулахгүй.

5. Үнэт цаасны захиалгын гэрээний захиалга гэсэн хэсгийг харилцагч үйлдэнэ. Нэг гэрээнд хэд хэдэн үнэт цаасны захиалга өгч болно. “Шимтгэл” хэсгийг тохиролцооны үндсэн дээр үйлдэнэ.

6. Захиалагч тухайн брокер-дилерийн компанитай холбооны хэрэгслээр захиалга өгч байх тухай итгэмжлэлийн гэрээ байгуулсан бол биечлэн ирж, захиалга өгөх шаардлагагүй. Итгэмжлэлийн гэрээг 2 хувь хийсэн, нотариатаар баталгаажуулсан байна. Хоёрдугаар хувийг тухайн брокер, дилерийн компанид хадгална.

7. Харилцагч захиалга/захиалгын үнэ, нөхцөлийг/ өөрчилсөн тохиолдолд Үнэт цаасны захиалгын гэрээний “Захиалгын төрөл, нөхцөл” хэсэгт өөрчлөлт оруулж болох ба эсхүл шинээр гэрээ байгуулж болно.

ГУРАВ. Үнэт цаасны захиалгын  
бүртгэл/маягт №А2-2/

8. Үнэт цаасны захиалгын бүртгэлийг брокер-дилерийн компани, түүний салбар бүрт хөтөлнө.

9. Захиалгыг нэг брокер дагнан бүртгэнэ. Түүний эзгүйд уг компанийн менежер/салбарын менежер/ хариуцан хөтөлж болно. Бүртгэл хөтлөгч үнэт цаасны захиалгын гэрээг үндэслэн түүнийг маягтаар нэгтгэнэ.

10. Үнэт цаасны захиалгын бүртгэл дэвтэр хэлбэртэй байна. Мөн компьютерийн санах төхөөрөмжинд шивж найдвартай хадгална. Бүртгэл хөтлөгч бүртгэлийг хөтлөх, хадгалах, хамгаалах талаар хариуцлага хүлээнэ.

11. Бүртгэл хөтлөгч харилцагчийн захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар нэгтгэн үнэт цаасны дилерийн даалгавар/маягт №А2-3А, маягт №А2-3Б/-ыг арилжаа явагдах өдрийн урьд өдөр бэлэн болгоно. Хэрэв арилжаа явагдах өдөр захиалгад өөрчлөлт орвол орсон өөрчлөлт, итгэмжлэлийн гэрээг үндэслэн үнэт цаасны дилерийн даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулна.

12. Бүртгэл хөтлөгч өдөр тутмын арилжааны хуулга, үнэт цаасны дилерийн даалгаврын биелэлтийг үндэслэн захиалгын бүртгэлд биелэлтийг тусгана.

ДӨРӨВ. Үнэт цаасны дилерийн даалгавар  
/маягт №А2-3А, маягт №А2-3Б/

13. Бүртгэл хөтлөгч тухайн өдрийн арилжаанд зориулсан худалдан авах захиалгын, худалдах захиалгын гэсэн үнэт цаасны дилерийн даалгаврыг хөтлөн холбооны хэрэгслээр дамжуулна. Үнэт цаасны дилерийн даалгаврыг тухайн компанийн менежер хянаж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

14. Үнэт цаасны дилерийн даалгаврын маягтад дилер дамжуулсан захиалгыг хуулбарлан буулгаж арилжаанд оролцоно. Дилер зөвхөн дамжуулан захиалгыг тэмдэглэж авах үүрэгтэй.

15. Тухайн компанийн салбар болгоноос ирсэн даалгаврыг дилерүүд хүлээн авч арилжаанд оролцоно.

16. Холбооны хэрэгслээр хүлээн авсан дилерийн даалгаврыг тухайн дилер өөрөө хадгалах үүрэг хүлээнэ.

Үнэт цаасны дилерийн даалгаврын биелэлтийн талаар дилер холбооны хэрэгслээр менежер болон салбарын менежерт өдөр тутмын арилжааны хуулгыг үндэслэн арилжаа явагдсан өдөрт нь мэдэгдэх үүрэгтэй. Менежер өөрт байгаа үнэт цаасны дилерийн даалгавар дээр хэлцлийн биелэлтийн талаар тэмдэглэл хийж, тухайн өдрийн арилжааны хуулгыг хүлээн авсны дараа баталгаажуулж, дилертээ хяналт тавина.

ТАВ. Дилерийн даалгавар/компанийн өөрийн  
захиалгын/ маягт №А2-3В

17. Компани өөрийн хөрөнгөөр арилжаанд оролцож дилерийн үйл ажиллагаа явуулахад энэ маягтыг хэрэглэнэ.

18. Тухайн компаниас захиалга өгөх эрхийг зөвхөн менежер эдэлнэ. Салбар компани дилерийн арилжаанд оролцож болохгүй.

19. Дилер болон менежер энэхүү маягтыг тус тусдаа хөтөлнө. Дилер менежерээс захиалга авмагц маягтад тэмдэглэн арилжаанд орно. Менежер захиалгаа дамжуулахдаа өөрийн маягтад тэмдэглэл хийнэ.

20. Дилер компанийн захиалгыг биелүүлэхдээ захиалгын үнэ тэнцсэн тохиолдолд харилцагчийн захиалгыг түрүүлж биелүүлэх үүрэг хүлээнэ.

---oOo---

Маягт №А2-1

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГЫН ГЭРЭЭ №  
 /энэ гэрээг 2 хувь үйлдэнэ/

-----/аймаг, хот/ дахь -----үнэт цаасны брокер дилерийн компани----  
 -----харилцах утас -----  
 Захиалагчийн овог, нэр, оноосон нэр-----  
 Дансны дугаар----- харилцах утас -----  
 Хаяг-----

Үнэт цаасны нэр, төрөл			
Захиалга өгсөн он, сар, өдөр, цаг, минут			
Худалдах эсхүл худалдан авах			
Захиалгын төрөл, нөхцөл			
Захиалга өгсөн үнэт цаасны	Тоо, ширхэг		
	Нэгжийн үнэ		
Худалдан авах мөнгөний дүн			
Захиалгын биелэлт	Он, сар, өдөр, цаг, минут		
	Тоо, ширхэг		
	Нэгжийн үнэ		
Худалдсан мөнгөний дүн			
Шимтгэл	Хувь		
	Дүн		

Захиалга өгсөн харилцагч -----/-----/

/гарын үсэг/ /овгийн эхний үсэг, нэр/

Захиалга хүлээн авсан брокер -----/-----/

/гарын үсэг/ /овгийн эхний үсэг, нэр/  
 200. оны .. сарын ..-ний өдөр

Тус захиалгын гэрээг/дуусгавар болгов эсхүл цуцлав/  
 /доогуур зурах/

Харилцагч -----

/гарын үсэг/ /овгийн эхний үсэг, нэр/

Брокер -----/гарын үсэг/ /овгийн эхний үсэг, нэр/

200. оны .. сарын ..-ний өдөр

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 20 дугаар тогтоолын  
2 дугаар хавсралт

Маягт №А2-2

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

-----/аймаг, хот/ дахь ----- брокер-дилерийн компани/салбар/

Захиалгын гэрээний дугаар	Харилцагчийн нэр	Дансны дугаар	Захиалга өгсөн он,сар,өдөр, цаг, минут	Худалдах, эсхүл худалдан авах	Захиалгын төрөл, нөхцөл	Үнэт цаасны нэр, төрөл	Захиалгын		Биелэлт		Хэлцлийн дугаар, хэлцэл хийсэн он,сар,өдөр,цаг, минут
							Тоо,ширхэг	Нэгжийн үнэ	Тоо,ширхэг	Нэгжийн үнэ	

Нэгтгэж бүртгэсэн -----/овог,нэр/

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 20 дугаар тогтоолын  
3 дугаар хавсралт

Маягт №А2-3А

ҮНЭТ ЦААСНЫ ДИЛЕРИЙН ДААЛГАВАР  
/худалдах захиалгын/

-----/аймаг, хотын/ дахь -----брокер-дилерийн  
компани/салбар/

200. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Үнэт цаасны нэр, төрөл /код/	Харилцаг-чийн дансны дугаар	Үнэт цаасны		Захиалгын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт	
		Тоо, ширхэг	Нэг- жийн үнэ		Тоо, ширхэг	Нэг- жийн үнэ

Захиалга нэгтгэсэн -----/гарын үсэг/

Захиалга хянасан-----/гарын үсэг/

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 20 дугаар тогтоолын  
4 дүгээр хавсралт

Маягт №А2-3Б

ҮНЭТ ЦААСНЫ ДИЛЕРИЙН ДААЛГАВАР  
/худалдан авах захиалгын/

Үнэт цаасны нэр, төрөл/код/	Харилцаг-чийн дансны дугаар	Үнэт цаасны		Захиал-гын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт	
		Тоо, шир-хэг	Нэг-Жийн үнэ		Тоо, шир-хэг	Нэг-жийн үнэ

Захиалга нэгтгэсэн -----/гарын үсэг/

Захиалга хянасан -----/гарын үсэг/

Монгол улсын Үнэт цаасны хорооны  
2003 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 20 дугаар тогтоолын  
5 дугаар хавсралт

Маягт №А2-3В

ҮНЭТ ЦААСНЫ ДИЛЕРИЙН ДААЛГАВАР  
/компанийн өөрийн захиалгын/

-----/аймаг,хот/ дахь ----- брокер-дилерийн компани/салбар/

200. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Захиалга өгсөн цаг, минут	Худалдах, эсхүл худалдан авах	Үнэт цаасны нэр, төрөл /код/	Үнэт цаасны		Захиал-гын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт	
			Тоо шир- хэг	Нэг- жийн үнэ		Тоо шир-хэг	Нэг- жийн үнэ

Захиалга өгсөн менежер-----/гарын үсэг/